

Тогтоа бэхи, Хэрэйдийн Ун хаан, Зажиран /Жадаран С.А./-ы хаан, Харлудын Арслан хаан, Ойрадын Хотоба бэхи, Хорь түмэдийн Ботохай тархун, Уйгурын Идүүд, Найманы Даян хаан, Татаарын Мэгүжин сүүлт, зургаан Зүрчидийн Занчун хаан, эд арван хоёр муу хаадыг эрхэндээ оруулж..." /1/ хэмээн тэмдэглэжээ.

Дээр өгүүлсэн XIII зууны үеийн тал нутгийн олон овог аймгийн хаадаас гадна сөрөг нөлөө үзүүлсэн ноёдууд ч бас түүхийн тавцанд эрээ цээргүй аашилж байлаа. Өдгөө бид тэдгээр ноёдын дотроос Тангудын тэргүүн сайд Аша хамбын талаар өөрийн олж цуглуулсан баримтан дээр тулгуурлан товч өгүүлэхийг оролдъё.

Түүхийн сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдийн мэдээнд сайхь хүмүүнийг хоёр янзаар тэмдэглэсэн байна. Эхнийх нь Лу.Алтан товчид "Эсэ хамба" гэж тэмдэглэсэн бол "Нууц товчоо" болон судалгааны зарим бүтээлүүдэд "Аша хамба" хэмээн бичжээ. Бидний мэдлэг нимгэн, үзсэн нь бага ч Тангуд хэлний үүднээс авч хэлбэл "Энсо буюу Енсо хамба" хэмээн нь болохоор шиг байна. Ийн үзэх нь хэдэн жилийн өмнө Хятадын телевизээр Монгол хэлээр гарсан нэг баримтат кино үзсэнээс үүдсэн билээ. Тэр кино нь Тангад үндэстний соёл, урлагийн талаар өгүүлж байна. Чингэхдээ Ен Хо, Ен Ша, Ен Бин зэрэг түүхт хүмүүс байдгийг дам сонсож байсан билээ. Үүнээс үндэслэн Аша хамба бус, Энша буюу Енша хамба хэмээн нэрлэх нь илүү зохимжтой мэт боловч дахин нягтлах шаардлага буй гэдгийг хэлмээр байна. Харин одоо энэ зүйлийг түр түдгэлзэн үндсэн асуудлаа нягтлан үзье.

Чингис хаан, Аша хамба нарын анх харилцсан мэдээг үг, үсэг зөрүүтэй ч утга нэгэн адил дурьджээ.

"Чингис хаан биеэр их цэрэг удирдан Тангуд иргэний Бурхан /Илагу ван.Г.С./ хаанд элч томилон илгээж:" баруун гар чинь болж хэмээв. Би Сартуул иргэнээ Алтан аргамжаа тасалдуулж ихэд хэлэгнэн морилов би. Баруун гар болон морил" хэмээн илгээвээс, Бурханыг донгодохоор одохуйд, урьд Аша хамба өгүүлрүүн, "хүч ядан хан байтал юун" хэмээж цэрэг үл нэгтгэн их үг өгүүлж илгээжээ. Тэнд Чингис хаан өгүүлрүүн: "Аша хамбатан хэрхэн ийн өгүүлэх бүлгээ" гээд "Энд бодвоос зам буруулан ялбаас юун бэрхэд бүлгээ. Өөр хүн зорьж буйд Тали мөнх тэнгэр та ивээгдвээс алтан жолоо бат татаж ирвээс энд болтугай" /2/ хэмээж Сартуул иргэнд араар даван морилруун. Чингис хаан хатдаасаа Хулан хатанг аван Сартуул иргэнийг байлдан номхотгох аян дайнд мордов. Дүү нараасаа Отчигин ноёныг Их

Аурагт тосож морилов. "Сартуул иргэнд долоон жил явж" тэнд Чингис хаан харих зуур Ирчис голд тахиа жилийн намар Туулын Хар түн ордондоо буув.

Тэр өвөл өвөлжиж "Тангуд иргэнд морилъё" хэмээн шинэ тоо тоолж нохой жилийн намар Чингис хаан Тангуд иргэнд морилов. Хатдаас Есүй хатанг авч одов. Явах зуур Арбугын шугуйд олон хулан авлаад Чингис хаан Зост бүрдийг үргэж, Чингис хааныг мориноос унаваас маш өвдөж, мориноос буув. Тэнд шөнө хоновоос Есүй хатан өгүүлрүүн: "Хөвгүүд ноёд бүгдээр хэлэлцэцгээгтүн. Хаан шөнө мариа /бие.Г.С./ их халуун хонов" /3/ гэжээ. Тэнд хөвгүүн ноёд гурваас Хонгодадай /Хонхотон/-н Долон Чэрби дурьдан өгүүлрүүн: "Тангуд иргэн:

"Нүдсэн балгас /нүдэх цохиж уран аргаар барьсан балгас/-тан

Нонж нутаг /дархан цаазат нутаг/-тан буйг

Нүдсэн балгасаа үүрч одогсод

Нонж нутгийг гэж үл одогсод. Бид ичиж хаан үзвээс Чингис хаан өгүүлрүүн: "Тангуд иргэн биднийг зүрх ядан яван одов хэмээв. Бид элчин мах өгч өвчнийг мөн энэ суун та сувилж, үгийг нь ухаж үзвээс болюу хэмээвэл тэнд элчингийн дуу бариулж илгээв. "Ноднин Бурхан чи өгүүлрүүн би Тангуд иргэн баруун гар чинь болбоос хэмжээнд чамд тийм хэмээгдэж Сартуул иргэнээ эе эвээ эс ороогдож морилсу хэмээн гуйж илгээвээс, чи Бурхан үгэндээ үл хүрэн цэрэг үл өгөн хатуу үгээр дайрч ирсэн буюу. Өөр зорьсонд хойно Сартуул иргэн морилж мөнх тэнгэрт ивээгдэж, Сартуул иргэнийг зүгт оруулж, эдүгээ Бурханд үг өчин зөв бурууг ялгасугай хэмээн илгээвэл, Бурхан өгүүлрүүн: "Дайрах муу үгийг би хэлсэнгүй" гэв. Аша хамбу өгүүлрүүн: "Дайрах үгийг би хэлэв. Одоо Монголчууд та нар байлдаж сураад, байлдъя гэвэл миний бүх Алашаа нутагт тэрэм /ханат/гэр, тэмээн ачаатай хүмүүс буй Алашаад аялж надад ирэгтүн. Тэнд байлдъя. Алт мөнгө, эд агуурс хэрэгтэй бол /Нин си/, Эрчигү/ Си лян/ хотод ирэгтүн" /4/ хэмээн илгээв. Энэ үгийг Чингис хаан сонсоод өгүүлрүүн: "Ийм их үг илгээж, гэр үзэгдэхүйд өгөвч их үгэнд шахан явъя" хэмээх "мөнх тэнгэр чи мэдтүгэй" хэмээн, Чингис хаанд Алашаа нутагт хүрч, Аша хамбатай хатгалдаж, Аша хамбыг дарж, Алашаа нутагт хураалгуулж, Аша хамбыг авч тэрэм гэрт, тэмээн ачаат иргэнийг нь хийстэл дагуулав. Баатар хүчтэй домгийн сайн эрчүүд Тангудыг хядаж, том бага гэлтгүй тангуд хүмүүнийг барьсаар, олсоор авагтүн" хэмээн зарлиг болгов.

Ийнхүү Чингис хаан Цаст уулын дээр зогсож, Аша хамбатай уулзаж, ууланд гарч дайжсан дарма гэртэн, тэмээн ачаатан Тангуд нарыг ялж, нүүдэлчдийн

хамгийн том дайснуудыг нэг Тангуд улсыг эрхэндээ оруулах эхлэлийг гүйцэтгэсэн байна.

Дүгнэлт: Энэ бүх баримтаас үзэхэд, XIII зууны үе бол зөрчил, ааг омог оргилон байсан үе мөн. Чингис хаан их үйл хэргийг өрнүүлж байхад дэмжигчид, дайсагнагчид аль аль нь байжээ. Чухамдаа зүй ёсны, жамаараа өрнөж буй үйл явцыг хэн ч өөрчилж, зогсоож үл чадах ажээ. "Их санасан газар хоосон хонох", "урт хэл хүзүү ороох" зэрэг ончтой үг байдаг. Энэ нь тухайн үеийн Их Монгол улс, Тангадын харилцаан дээр бодитой илэрчээ. Бидний бодоход, Тангадын Бурхан хаан, тэргүүн сайд Аша хамба нарын хэлсэн үг нь өөрсдийнх нь санаа биш, Алтан улсын нөлөө, хятад ухаан, заль мэхийн илрэл юм. Тэгээд ч хүчинд автаж ялагдаад ирэхэд хаан нь булзаж, түшмэл нь хүлээж, бодлогогүй хорон үгийн золиосонд ард иргэд нь хөнөөгдсөн байна.

Аша хамба бол ааш түргэн, омог бардам, сүр үзүүлэгч хэтэрхий биеэ тоосон нэгэн байсан болов уу хэмээн үзэлтэй. Энэ удаад бид нэгэн баримтыг түшиж товч өгүүлж байгаа хэдий ч цаашид судалгааг гүнзгийрүүлэх эхлэлийг тавьж буй хэрэг юм. Ялангуяа Хятадын түүх, Тангадын талаар сурвалж, судалгааны бүтээлүүдийг нягтлан тунгаавал сонирхолтой, өвөрмөц баримт сэлт цөөнгүй олдох буй за.

Эцэст нь тэмдэглэхэд, аливаа улс төр түшилцэж буй хэн боловч хэлэх үг, хийх үйл, эзлэх байр суурь, ирээдүй хойчоо бодож хэрсүү, ноён нуруутай, ул суурь сайтай, ухаалаг байх ёстой гэсэн сургамж Аша хамбатан зэргийн алдаа эндүүрлээс ажиглагдаж байна.

Резюме: 3 всех этих исторических фактов мы узнали много об этом человеке. И пришли к такому выводу, что Аша хамба был человеком очень вспыльчивого, гордого, величественного и в тоже время слишком хвастливого характера. Опирая на данные факты, в этот раз мы попытались коротко рассказать об этом историческом лице.

Мы уверены, что наша работа в дальнейшем будет служить мерилom более углублённого исследования этой работы.

Ном зүй

1. Лу. Алтан товч /хэвлэлд бэлтгэсэн Ц.Шагдар/ УБ., 1990 т.148
2. Дорнотив.Монгол үндэстний сонгодог зохиолын сонгомол.Хөх хот.1980.т.198
3. Мөн тэнд. т.200
4. Монголын нууц товчоо /нэмж засварласан тавдахь хэвлэл/ УБ.,2004 т.74

АВИР ТҮРГЭН АША ХАМБА

С.Азбилэг

Их Монгол дээд сургууль, Түүх, нийгэм, орон судлалын тэнхим

Өгүүллийн товч утга: Энэ өгүүлэлд Тангадын Бурхан хааны дүү Аша хамбын тухай товч авч үзнэ. Түүний омог бардам сэтгэл зүйн дотоод ертөнц рүү товчхон ч атугай өнгийж харахыг эрмэлзсэн юм.

Түлхүүр үг: Тангад, сайд, сайрхал, ялагдал, эмгэнэл

МЭӨ III зууны үеэс монгол нутагт түүхийн давалгаа савалгаанууд үргэлжлэн Хүннү гүрнээс эхлэн төр улсын мандал буурал ээлж дараалан өрнөсөн түүхтэй. Нирунчууд түрэгүүдэд ихэд цохигдож, Эргүнэ кунд очсоноос хойш бараг 400 орчим жил болоод, VIII зууны үеэс монгол угсаатны аймгууд эх нутагтаа уван цуван иржээ. Чухам тэр үеэс монгол аймгууд түүхийн тавцан дээр товойн гарч ирсэн бүлгээ. Энэ бол их зөрчил тэмцлийн үе байсан юм. Харь угсаатны дотроос хань болох хүмүүс байсан байхад, харин угсаа язгуур нэгтнүүдийн дотроос уралцах дайсан ч бий болж “одтой тэнгэр орчиж олон улс байлдаж, орондоо унтах завгүй олзлолдон булаалдаж” байжээ.

XII зууны эцсээр ааг омог нь бадарсан монголчууд өөр зуураа өрсөлдөж, Хамаг Монголын ханлиг бусдыгаа манлайлан хатуу ширүүн тулалдаанд хамгаас одтой байв. Есүхэй баатрын хүү Тэмүжин бага наснаас өнчрөн, БурханХалдун уулаа бараадан бусдын дэмжлэгийг авч бутарсан улсаа хурааж нэгэн дээвэр нэгтгэсэн билээ. Чингис хааны тэргүүлсэн Их Монгол улсад чин сүжгээр эвлэлдэн нэгдэгчид байхад, чадал мөхөс ч эсэргүүцэн тэмцэгчид бас байсан ажээ. Тэдний нэг нь Си ся буюу Тангад улс байв. Ялангуяа Тангадын хаан Бурхан, тэргүүн сайд Аша хамба нарын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг сайтар эргэцүүлэн үзүүштэй юм.

Монгол түмний цадиг түүхийн алтан шаргал хуудас цэн цэнгээр нэмэгдсээр... Уул нуруудыг ганхуулж, ус мөрнийг цалгиулан, төр гүрний өрхийг татаж, галыг асаалцсан баатар эрс улаан зүрхээ үлдээж, түүх шастирийг гийгүүлсэн тэр цаг өчигдөр мэт.

“Уулын мод урттай богинотой, хүний олон сайнтай муутай” хэмээх ардын мэргэн үг буй. Төр гүрний хэрэгт нэгэн сэтгэлээр зүтгэсэн эрс олон байдаг ч мөн үүний эсрэг тэрсэлдсэн дайснууд ч байдаг.

Түүхийн сурвалж бүтээлүүдэд: “...өөр өөрөө эрхшээсэн арван хоёр муу хаад хэмээвээс, Тайчуудын Таргудай Хирилтуг, Жүрхэний Сачи Бэхи, гурван Мэргэдийн